



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 1419

Мандалговь

Өрхийн эмнэлгийн автомашиныг  
худалдах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журамын 3 дугаар зүйлийн 3.1“в” 3.2.6-гийн “а” заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн “Өлзийт Мандал” өрхийн эмнэлгийн эзэмшилд байгаа төвийн түргэн тусламжид явж байсан Logo маркийн ДУА 39-69 улсын дугаартай автомашиныг “Өлзийт Мандал” өрхийн эмнэлгийн санал, байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт зэрэг баримт бичигт дурдсанаар ажлын шаардлага хангахгүй болсон тул данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. 1997 онд ашиглалтад орсон ДУА 39-69 улсын дугаартай Logo маркын автомашиныг 600.0 мянган төгрөгөөр худалдах доод үнийг тогтоон дуудлагаар худалдсугай.

3. Автомашиныг хүлээн авч дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Орон нутгийн өмчийн албанд даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНГӨНЦООЖ

36